



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 06 он 06
сарын 20 өдөр

Дугаар 35-1/101

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Д.ОЮУН-ЭРДЭНЭ

000224002201



МОНГОЛ УЛС

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ~~22~~ он 06 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар ~~...~~ хэрг /1411

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ~~313~~ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга




Ц.НЯМДОРЖ


000225007072

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлд:

"ҮЙ.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон "Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцээд "Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160-Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2022.06.16 № 1/3379
танай 2022.06.15-ны № 01/4156т

**САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151602973
A5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022.06.15 № 01/4157
танай _____-ны № _____-т


Өргөн мэдүүлэх зөвшөөрөл
олгох тухай

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу "Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762003353



**МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлага бүхий 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагыг тусгасан 2 зүйлтэй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгана. Үүнд:

- 1.Тухайн жилийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүн, хөтөлбөр, төсвийн захирагч болон хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр гаргасан тайлан;
- 2.Татварын зарлагыг хуулийн этгээд болон салбар бүрээр нь холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт гаргасан тайлан;
- 3.Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан;
- 4.Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт болон тасарсан бол шалтгаан);
- 5.Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан болон түүний танилцуулга зэрэг болно.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвийн 2021 оны орлого, зарлагын нийт хэмжээ батлагдаж, төсвийн ашиг, алдагдлыг тодорхойлох боломжтой болно.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

--oo00oo--

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 9,053,146.8 сая /есөн их наяд тавин гурван тэрбум нэг зуун дөчин зургаан сая найман зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

2. Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 12,160,840.4 сая /арван хоёр их наяд нэг зуун жаран тэрбум найман зуун дөчин сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

ГАРЫН ҮСЭГ



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН
2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА 2	
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ.....	3
1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ.....	8
1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого.....	10
1.2. Нэгдсэн төсвийн зарлага	11
1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	12
1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал.....	14
1.5. Татварын зарлага.....	17
1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	18
1.7. Нэмэлт төсөв	22
2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ	23
2.1. Улсын төсвийн орлого.....	23
2.2. Улсын төсвийн зарлага	25
2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт.....	26
2.4. Засгийн газрын нөөц сан	30
3. ИРЭЭДҮЙН ӨВ САН.....	31
4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН.....	32
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ.....	33
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ.....	35
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ.....	37
8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	39
8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС	41
8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС.....	42
8.3. ГАДААД ЗЭЭЛ.....	43
8.4. БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ ТӨРЛИЙН КОНЦЕСС	44
8.5. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА	45
8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ	46

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Танилцуулгад улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагч болон нийслэл, дүүргүүд, 21 аймгийн 4,674 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно.

Түүнчлэн Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2021 онд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2021 онд 14,306.4 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,919.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсвийн тогтворжуулалтын санд 627.9 тэрбум, Ирээдүйн өв санд 967.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал 2021 онд хүнд хэвээр үргэлжилсэн хэдий ч бэлэн байдлын зэргийг үе шаттай бууруулж, Монгол Улсын Засгийн газрын зүгээс иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах чиглэлээр бодлогын арга хэмжээ авч, "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-г батлан, хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийн өсөлт 2020 оноос 6 нэгж пунктээр өсөж 1.4 хувь хүрсэн.
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилгоор "Сенчири" бондыг арилжаалж, Чингис болон Гэрэгэ бондын зарим хэсэг болох нийт 944.5 сая ам.доллар буюу 2,647.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан
- Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 онд 16.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 25.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Эдийн засгийн өсөлт. Нэрлэсэн ДНБ 2021 онд 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 27 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 5.5 хувиар, барилгын салбар 32.7 хувиар, тээврийн салбар 16.7 хувиар тус тус агшсан нь бодит өсөлт буурахад голлон нөлөөлсөн бол уул уурхайн салбарын өсөлт болон дотоодын эдийн засгийн сэргэлт нь эдийн засгийн агшилтыг хязгаарлахад гол хувь нэмэр оруулсан байна.

Дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт нэмэгдэж, манай улсын уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспорт 2021 оны эхэнд хурдтай нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж байсан бол оны сүүлд Ковид-19 цар тахлын улмаас хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдож, түүхий эдийн экспорт огцом буурсан нь эдийн засгийн өсөлтийг хязгаарласан байна. Уул уурхайн салбарын өсөлт эхний улирал 39.3 хувь байсан бол оны эцэст 1.7 хувь болж саарсан байна. 2021 онд зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оноос 4.0 хувиар өсөж, 1326.4 мянган тонн, газрын тосны үйлдвэрлэл 13.7 хувиар өсөж, 4.7 сая баррельд хүрсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжсэн байна.

ХАА-н салбар 2021 онд 5.5 хувиар буурсан ба үүнд том малын зүй бус хорогдол өндөр байсан нь голлон нөлөөлжээ. Зарим аймгуудад оны эхний улиралд тохиолдсон байгаль, цаг уурын нөхцөл байдал хүндэрснээс шалтгаалан зүй бус хорогдол 2021 онд 45.6 хувиар өсөж, бойжуулсан төл 2020 онтой харьцуулахад 10.8 хувиар буурсан байна.


Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2018	2019	2020	2021*
Эдийн засгийн өсөлт	7.7	5.6	-4.6	1.4
Хөдөө аж ахуй	6.5	5.2	5.8	-5.5
Үйлдвэрлэл	8.5	3.1	-4.4	-2.8
Уул уурхай	5.4	-1.6	-9.9	1.7
Боловсруулах	19.5	3.8	3.4	0.3
Цахилгаан	8.6	7.7	2.6	10.6
Барилга	1.8	20.3	-3.2	-32.7
Үйлчилгээ	5.1	6.4	-6.5	3.9
Худалдаа	0.1	10.9	-12.5	9.3
Тээвэр	14.6	4.4	-18.2	-16.7
Бусад	4.8	4.6	-2.6	4.6
Цэвэр татвар	20.4	9.6	-9.4	12.2

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо урьдчилсан гүйцэтгэл*

Инфляц. Инфляцын түвшин 2021 оны эцэст улсын хэмжээнд 13.4 хувьтай гарлаа. Инфляцын өсөлтөд тээвэр, логиcтикийн саатал, тээврийн зардлын өсөлт, худалдааны түнш орнуудын инфляц нэмэгдсэн хүчин зүйлс болон төсөв, мөнгөний тэлэх бодлогын дүнд мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 1. Жилийн инфляц ба суурь инфляц



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк


Хүнсний бүлгийн үнэ 2021 онд 20.4 хувиар өссөн нь нийт инфляцын өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Хүнсний инфляц өссөн нь Ковид-19 цар тахалтай иргэдийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний нөөцлөлт, тээвэр логиcтикийн саатал, олон улсын зах зээл дээрх хүнсний инфляц зэрэгтэй холбоотой байна. Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлт 2021 он гарснаар саарсан хэдий ч суурь үеийн нөлөөгөөр инфляц өсөхөд нөлөөлсөн байна. Тээврийн бүлгийн үнэ 2021 онд 21.6 хувиар өссөн ба үүнд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтийг даган шатахууны жижиглэнгийн үнэ төрлөөсөө хамааран 2021 онд 37.7-54.4 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлээ. Мөн түлшний модны үнийн өсөлт болон “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үнийн зохицуулалттай холбоотойгоор орон сууц, ус, цахилгааны бүлгийн үнэ 2021 онд нэмэгдсэн нь инфляц өсөхөд нөлөөлсөн нэг хүчин зүйл болжээ.

Зураг 2. Инфляцын бүтцийн задаргаа




Гадаад худалдаа. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 онд 16.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 25.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна. Экспортоор 9.2 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь 2020 оноос 22.1 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор экспортын орлого нэмэгдсэн байна. Импортоор 6.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд худалдан авсан нь өмнөх оноос 29.4 хувиар өсжээ. Импортын өсөлтөд тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн бүтээгдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмж, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний импорт голлон нөлөөлсөн байна.

Зураг 3. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, тэрбум ам.доллар



Зураг 4. Төлбөрийн тэнцэл, гүйцэтгэл, сая ам.доллар



Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл 2021 онд 222 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал дансны алдагдал өмнөх оноос 1,284 сая ам.доллараар нэмэгдэж, 1,959 сая ам.долларт хүрсэн бол санхүүгийн дансны ашиг 331 сая ам.доллараар нэмэгдэн 1,835 сая ам.долларт хүрлээ. Урсгал дансны алдагдал ийнхүү нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал өмнөх оноос 939 сая ам.доллараар нэмэгдсэн, импортын өсөлтөөс шалтгаалан барааны дансны ашиг 453 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө. Харин хөрөнгийн дансны тэнцэл өмнөх оноос 24 сая ам.доллараар нэмэгдэж, 127 сая ам.долларт хүрсэн байна.

Хөрөнгө оруулалтын буцаалтыг оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2021 онд өмнөх оноос 24 хувиар өсөж, 2.1 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнд хувьцаа хэлбэрийн хөрөнгө оруулалт 87 хувиар өссөн нь нөлөөлжээ. Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллээр 2021 онд нийт 92 гадаадын хөрөнгө оруулалттай ХХК шинээр бүртгүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 21-ээр буюу 30.0 орчим хувиар өссөн үзүүлэлт байна. Харин өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын урсгал өмнөх оны түвшнээс 171 сая ам.доллараар бага байлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дийлэнхийг бүрдүүлдэг Оюу Толгойн хөрөнгө оруулалт 0.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 100 орчим сая ам.доллараар буурсан байна.

Өнгөрсөн онд “МИК ОССК” ХХК 250 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд арилжаалж, 2019 онд гаргасан 300 сая ам.долларын бондын тодорхой хувийг дахин санхүүжүүлжээ. Мөн Монгол Улсын Засгийн газар 2021 оны 6 дугаар сард “Century” төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бонд арилжаалж, 2022 онд төлөгдөх Чингис, 2023 онд төлөгдөх “Гэрэгэ” бондыг дахин санхүүжүүлж, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа.


Ажил эрхлэлт, ажилгүйдэл. 2020 оны сүүлийн улирал болон 2021 оны эхний улиралд нийт 60 хоног хатуу хөл хориотой тогтоосны улмаас ажиллах хүчний оролцооны түвшин 2020 оны 4 дүгээр улиралд 2 нэгж хувиар, 2021 оны 1 дүгээр улиралд 2.1 нэгж хувиар тус тус буурч, 54.9 хувьд хүрээд байсан юм. Засгийн газраас шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг хадгалах зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, хөл хориог үе шаттайгаар сулруулсан нь дотоодын эдийн засаг ялангуяа, үйлчилгээний салбарыг идэвхжүүлж, иргэдийн ажиллах сонирхлыг

нэмэгдүүлснээр хөдөлмөрийн зах зээл сэргэж, 2021 оны 4 дүгээр улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувьд хүрлээ. Түүнчлэн, ажиллагчдын тоо оны эцэст 1 сая 127 мянга болж, 1 дүгээр улиралтай харьцуулахад шинээр 72 мянгаар нэмэгдсэн байна.

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2021 онд 14.3 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 627.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 967.0 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12,711.4 тэрбум төгрөг болсон. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 15,630.4 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,919.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн¹-ий -6.8 хувьтай тэнцэж байна.

**Зураг 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт
/2015- 2021 он, тэрбум төгрөг/**



Тогтворжуулалтын сан: Дэлхийн зах зээл дээрх зэсийн зах зээлийн үнэ харьцангуй өндөр гарсны улмаас Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн

¹ ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 43,018,624.3 сая төгрөг
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

хэмжээнээс 15.2 тэрбум төгрөгөөр илүү буюу 627.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Ирээдүйн өв сан: Ирээдүйн өв санд 2021 онд 1,062.4 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 967.0 тэрбум төгрөг төвлөрөн 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар тус сангийн хуримтлал 2,565.9 тэрбум төгрөг байна.

1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2021 онд 12,711.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 3.9 хувь буюу 478.6 тэрбум төгрөгөөр давж төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 3,247.6 тэрбум төгрөгөөр буюу 34.3 хувиар нэмэгдсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 99.6 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 102.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 105.3 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 113.9 хувь байна.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,908.0	14,306.4	102.9	398.3
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	612.8	627.9	102.5	15.1
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1,062.4	967.0	91.0	(95.4)
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,232.9	12,711.4	103.9	478.6
1.Татварын орлого	10,707.8	11,299.9	105.5	592.1
Орлогын албан татвар	3,061.4	3,326.1	108.6	264.6
Нийгмийн даатгалын орлого	1,882.1	2,286.0	121.5	403.9
Хөрөнгийн албан татвар	183.0	201.1	109.9	18.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,804.0	2,837.7	101.2	33.7
Онцгой албан татвар	879.2	827.0	94.1	(52.2)
Тусгай зориулалтын орлого	15.0	16.6	110.7	1.6
Гадаад үйл ажиллагааны орлого	935.0	938.9	100.4	3.9
Бусад татвар, төлбөр, хураамж	948.1	866.5	91.4	(81.6)
2.Татварын бус орлого	1,525.0	1,411.5	92.6	(113.5)

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 11,299.9 тэрбум төгрөгт хүрч, 105.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Онцгой албан татвар 52.2 тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 81.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелж, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 403.9 тэрбум төгрөг, орлогын албан татвар 264.6 тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 18.1 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 33.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан нь татварын орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс 592.1 тэрбум төгрөгөөр давахад голлон нөлөөлсөн байна.

1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 онд 15,630.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 3.5 хувь буюу 573.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,204.1	15,630.4	(573.7)
А. УРСГАЛ ЗАРДАЛ	13,460.8	12,804.0	(656.8)
1. Бараа, ажил үйлчилгээний зардал	4,955.8	4,702.0	(253.8)
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,593.0	2,531.7	(61.3)
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296.3	271.3	(25.0)
3. Хангамж, бараа материалын зардал	195.3	187.6	(7.7)
4. Норматив зардал	273.6	262.3	(11.3)
5. Эд хогшил, урсгал засварын зардал	129.1	119.0	(10.0)
6. Томилолт, зочны зардал	25.6	20.0	(5.6)
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	881.1	805.6	(75.5)
8. Бараа үйлчилгээний бусад зардал	561.8	504.5	(57.3)
2. Хүү	971.5	835.6	(135.9)
3. Татаас	501.0	453.7	(47.3)
4. Урсгал шилжүүлэг	7,032.4	6,812.6	(219.8)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,304.7	2,982.2	(322.4)
1. Барилга байгууламж	2,078.2	1,941.1	(137.2)
2. Их засвар	147.2	128.5	(18.7)
3. Тоног төхөөрөмж	428.7	409.4	(19.4)
4. Бусад хөрөнгө	635.0	487.9	(147.2)
5. Стратегийн нөөц хөрөнгө	15.4	15.4	(0.0)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(561.3)	(155.8)	405.5
1. Эргэж төлөгдөх зээл	(712.3)	(311.6)	400.7
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	151.0	155.9	4.9

Хөрөнгийн зардал 322.4 тэрбум төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 253.8 тэрбум төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 219.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөв тус бүрээр ангилан харуулбал; улсын төсөв 3.2 хувь буюу 407.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 9.8 хувь буюу 382.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс дутуу байна.

Хүснэгт 4. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2021 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	16,204.1	15,630.4	(573.7)
Улсын төсөв	12,568.7	12,160.8	(407.9)
Орон нутгийн төсөв	3,883.5	3,501.4	(382.1)
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	1,074.3	1,200.9	126.6
Нийгмийн даатгалын сангийн төсөв	2,490.5	2,535.8	45.3

1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,919.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Хүснэгт 5. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2021 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нэгдсэн төсөв	(3,971.2)	(2,919.0)	1,052.2
Улсын төсөв	(3,476.9)	(3,107.7)	369.3
Орон нутгийн төсөв	(279.4)	191.3	470.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	(123.0)	(198.8)	(75.8)
Нийгмийн даатгалын сангийн төсөв	(91.9)	196.2	288.1

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 3,107.7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 198.8 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин орон нутгийн төсвийн тэнцэл 191.3 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 196.2 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 2,647.9 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт нийт 945.7 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 216.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2021 онд Төсвийн тогтворжуулалтын сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т заасны дагуу 728.8 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлсэн.

Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	ЭМДС	НДС
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,919.0	-3,107.7	191.3	-198.8	196.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,919.9	3,107.7	191.3	-198.8	196.2
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,919.0	2,108.0	191.3	-198.8	196.2
ЗГ-ын бонд	-392.5	-392.5	0.0	0.0	0.0
Урт хугацаат	-392.5	-392.5	0.0	0.0	0.0
Дотоод	-216.0	-216.0	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-216.0	-216.0	0.0	0.0	0.0
Гадаад	-176.5	-176.5	0.0	0.0	0.0
Шинээр гаргах	2,849.2	2,849.2	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-3,025.7	-3,025.7	0.0	0.0	0.0
ЗГ-ын зээл	663.0	663.0	0.0	0.0	0.0
Гадаад	663.0	663.0	0.0	0.0	0.0
Төслийн зээл	378.0	378.0	0.0	0.0	0.0
Шинээр авах	1,110.8	1,110.8	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-732.9	-732.9	0.0	0.0	0.0
Хөтөлбөрийн зээл	285.0	285.0	0.0	0.0	0.0
Шинээр авах	285.0	285.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	728.8	728.8	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	0.8	0.5	0.3	0.0	0.0

1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Төсвийн орлогын тусгай шаардлага: Монгол Улсын 2021 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2021 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg” терминал, “Чикаго металлын бирж” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2021 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,456.1 ам.доллар, нүүрсний үнийг 76.3 ам.доллар байхаар тооцож, Төсвийн тогтворжуулалтын санд 612.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 7. 2021 он зэсийн зах зээлийн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Тэнцвэржүүлсэн	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс, ам.доллар	8,550.0	5,456.1	9,314.4	764.4

Дэлхийн зах зээл дээрх зэсийн зах зээлийн үнэ 2021 оны турш харьцангуй өндөр гарсны улмаас Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс 15.2 тэрбум төгрөгөөр илүү буюу 627.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн тэнцлийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон

дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэж тусгасан.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

		2021 он
1	Хуулиар тогтоосон хязгаар	-8.8%
2	Гүйцэтгэл	-6.8%

2021 оны төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл - 2,908.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -6.8 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг хангаж байна.

Зарлагын өсөлтийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

Хүснэгт 9. Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

		2021 он
1	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	12.2%
2	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	12.8%
3	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	16.2%

2021 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь 12.2 хувьтай байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг хангаж байна.

Өрийн тусгай шаардлага: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2021 оны төсвийн жилд 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2021 оны эцэст 26.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн

үлдэгдэл 21.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 50.7 хувьтай тэнцүү байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тухай тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж тус тус заасан бөгөөд одоогийн байдлаар 240 гаруй төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 968.6 тэрбум төгрөг² буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 7.6 хувьд хүрэхээр байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 10. Татварын зарлагын хэмжээ/ тэрбум төгрөг/

Байгууллага	2021 он	Бүтэц хувиар
Татварын байгууллага	642.2	66.3%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	287.9	29.7%
Хувь хүний орлогын албан татвар	181.6	18.7%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	172.8	17.8%
Гаалийн байгууллага	326.3	33.7%
Гаалийн албан татвар	72.5	7.5%
Онцгой албан татвар	129.6	13.4%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	124.2	12.8%
Нийт татварын зарлага	968.6	100.0%

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 66.3 хувь буюу 642.2 тэрбум төгрөгийг татварын алба, 33.7 хувь буюу 326.3 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

² Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар тушаалаар батлагдсан “Татварын зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-д заасны дагуу зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын зарлагад хамруулахгүйгээр туссан бөгөөд журамд заасны дагуу татварын зарлагын гүйцэтгэлийн мэдээг гаргав..

1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” /цаашид “журам” гэх/-ын 5 дугаар хэсэгт заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн нэгтгэн дүгнэсэн болно.

Журам шинэчлэн баталсантай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайланд үнэлгээ өгч дүгнээгүй бөгөөд журмын 5.2 зааснаар Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын нэгж нь 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг цахим системээр хүлээн авч 50 төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөсөн байдал: Хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт зааснаар нийт 2,694 захиалагч бүртгүүлснээс 512 захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж ажилласан байна.

Цахим системийн мэдээллээс үзэхэд Нийслэлийн Засаг даргын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 172 удаа, Эрүүл мэндийн сайдын багцын төлөвлөгөөнд 122 удаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын төлөвлөгөөнд 98 удаа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяа байгууллагуудын төлөвлөгөөнд 71 удаа өөрчлөлт оруулсан байна. Төлөвлөгөөнд байнга өөрчлөлт оруулах нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдах, улмаар төсвийн жил дамжих, улирлын чанартай ажлын хувьд хэрэгжихгүй байх сөрөг талтай байдаг.

Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг баримталсан байдал: Цахим системээр 1,416 захиалагч нийт 21,739 тендерийн урилгыг зарласан байна. Нийт 84.5 хувь буюу 8.8 их наяд төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2.9 хувь буюу 306.6 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 1.8 хувь буюу 192.3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, 7.1 хувь буюу 746 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг гэрээ шууд байгуулах аргаар, 0.54 хувь буюу 56.3 тэрбум төгрөгийг шууд худалдан авалтаар, 2.9 хувь буюу 301.3 тэрбум төгрөгийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар, 0.02 хувь буюу 2.08

тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус зохион байгуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2021 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 10.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн онд санхүүжих дүн нь 6.1 их наяд төгрөгийн худалдан авалт зохион байгуулснаас 7.4 их наяд төгрөгийн худалдан авалтыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс зохион байгуулсан байна. Хамгийн өндөр өртөгтэй 2,229.28 тэрбум төгрөгийн төсөвтэй тендер шалгаруулалтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан “Цанхын зүүн уурхайн гэрээт олборлогч”-ийг сонгох тендер шалгаруулалт байна.

Хүснэгт 11. Тендер шалгаруулалт /тэрбум төгрөг/				
Д/д	ЗАХИАЛАГЧИЙН НЭР	ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТУХАЙН ОНД САНХҮҮЖИХ ДҮН
1	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч	2,229.28	62.20
2	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх	956.45	956.45
3	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Бортээгийн уурхайн гэрээт олборлогч	715.96	42.00
4	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Цанхийн зүүн уурхайн өрөмдлөг, тэсэлгээ	239.10	7.83
5	Улаанбаатар төмөр зам нийгэмлэг	Илчит тэрэгний өвөл, зуны дизелийн түлш худалдан авах	211.35	211.35


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны талаар: Монгол Улсын 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 458 төсөл, арга хэмжээнд 949.2 тэрбум төгрөг батлагдаж 2021 онд 478.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 410.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 85.8 хувьд хүрсэн байна.

Хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дах хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнээс төсвийн жилд Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 тогтоолоор баталсан.

Дээрх тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагч 434.2 тэрбум төгрөгийн 126 төсөл, арга хэмжээ, Төрийн худалдан авах ажиллагааны газар 265.6 тэрбум төгрөгийн 121 төсөл, арга хэмжээ, орон нутагт 254.1 тэрбум төгрөгийн 211 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар хуваарилсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	112	185,247.70	72,041.40
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	89	114,407.70	50,107.50
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	51	164,152.40	138,326.10
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	34	83,664.10	30,562.20
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	28	38,523.40	17,447.00
СОЁЛЫН САЙД	27	74,734.00	28,122.70
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	25	51,257.20	12,646.00
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	22	30,564.70	9,802.40
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	16	40,869.80	15,600.50
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	14	28,924.70	9,804.70
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	13	34,615.00	8,015.00
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	7	5,148.00	2,348.00
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	5	14,961.30	12,624.30
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	2	4,349.40	4,349.40
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2	1,150.00	1,150.00
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	2	1,600.00	1,600.00
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	2	4,000.00	4,000.00
САНГИЙН САЙД	2	69,000.00	69,000.00
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1	100.00	100.00
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1	1,066.60	1,066.60
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1	3,570.30	3,570.30
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1	1,497.30	1,497.30
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1	492.50	492.50
Grand Total	458	953,896.10	494,273.90

Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 40.5 тэрбум төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасны дагуу төрийн нууцад хамаарах тул тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна. Сангийн сайдын багцаас санхүүжүүлэх Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төсөл, хилийн боомтын дэд бүтцийн хүрээнд хийгдэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээ хүрээнд худалдан авах ажиллагааг тухайн зээлийн хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулсан байна.



Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан байдал: Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлахаар хуульчилсан. Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Тайлант хугацаанд нийт 21,586 тендер шалгаруулалт буюу 99.3 хувийг цахим системээр зохион байгуулсан байна.

1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт төсвийн эх үүсвэрт 2021 онд 1,696.5 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Нийт эх үүсвэрийн 546.6 тэрбум төгрөг буюу 32.2 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 1,149.9 тэрбум төгрөг буюу 67.8 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна. Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 327.2 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 121.6 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,028.3 тэрбум төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 186.3 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 33.1 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Тайлант онд нэмэлт төсвөөр 1,686.8 тэрбум төгрөг зарцуулалт гарсан байна. Нийт зарлагын гүйцэтгэлийг сайдын багцуудаар авч үзвэл:

Эрчим хүчний сайд 764.3 тэрбум төгрөг буюу 45.3 хувь, Эрүүл мэндийн сайд 257.7 буюу 15.3 хувь, Батлан хамгаалахын сайд 149.7 тэрбум төгрөг буюу 8.9 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 73.9 тэрбум төгрөг буюу 4.4 хувь, Улаанбаатар хот 71.5 тэрбум төгрөг буюу 4.2 хувь, Шадар сайд 44.7 тэрбум төгрөг буюу 2.6 хувь байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас зардал 764.6 тэрбум төгрөг 45.3 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 238.8 тэрбум төгрөг 14.1 хувь, урсгал шилжүүлэг буюу засгийн газрын урсгал шилжүүлэг, бусад урсгал шилжүүлэг, төвлөрүүлэх шилжүүлэг 217.1 тэрбум төгрөг 12.9 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 135.1 тэрбум төгрөг 8.0 хувь, нормативд зардал 120.5 тэрбум төгрөг 7.1 хувь, томилолт, зочны зардал 55.8 төгрөг 3.3 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 45.3 тэрбум төгрөг 2.7 хувийг эзэлж байна.

2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн бөгөөд Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлэн зарцуулах төсөв юм.

Монгол Улсын 2021 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 9,053.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 12,160.8 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 3,107.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2021 онд 9,053.1 тэрбум төгрөгт хүрч, 99.6 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 34.5 тэрбум төгрөг дутуу, харин өмнөх оны гүйцэтгэлээс 2,228.2 тэрбум төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,767.0	10,648.1	(118.9)
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	612.8	627.9	15.1
ИРЭЭДҮЙН ӨВ САН	1,062.4	967.0	(95.4)
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,091.8	9,053.1	(38.7)
Татварын орлого	7,254.2	7,361.3	107.1
Орлогын албан татвар	2,010.9	2,211.6	200.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,804.0	2,837.7	33.7
Онцгой албан татвар	879.2	827.0	(52.2)
Тусгай зориулалтын орлого	15.0	16.6	1.6
Гадаад үйл ажиллагааны орлого	935.0	938.9	3.9
Бусад татвар, төлбөр, хураамж	610.1	529.5	(80.6)
Татварын бус орлого	1,837.6	1,691.9	(145.7)
Нийтлэг татварын бус орлого	1,137.5	988.6	(148.9)
Тусламжийн орлого	171.3	176.5	5.2
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	528.8	526.8	(2.0)

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 81.3 хувь татварын орлогоос, 18.7 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна.

Орлогын албан татвар 2021 онд 2,010.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 2,211.6 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, төлөвлөснөөс 200.7 тэрбум төгрөгөөр их буюу 110.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Орлогын албан татвар өмнөх оноос өссөн нь Бөөний болон жижиглэн худалдаа, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, Уул уурхай, олборлолтын салбарын үйл ажиллагаа сэргэсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 528.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 526.8 тэрбум төгрөг буюу 2.0 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2021 онд 12,160.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 407.9 тэрбум төгрөг буюу 3.2 хувиар бага гарсан байна.

Улсын төсвийн урсгал зардалд 9,753.8 тэрбум, хөрөнгийн зардалд 2,543.7 тэрбум төгрөгийг зарцуулсан ба эргэж төлөгдөх цэвэр зээл -136.7 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 13. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,568.7	12,160.8	(407.9)
НИЙТ ЗАРЛАГА	12,927.5	12,297.5	(630)
УРСГАЛ ЗАРДАЛ	10,256.9	9,753.8	(503.1)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,785.4	2,639.3	(146.1)
ХҮҮ	965.5	829.6	(135.9)
ТАТААС	843.5	810.9	(32.6)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,662.5	5,474.0	(188.5)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,670.6	2,543.7	(126.9)
Дотоод эх үүсвэрээр	2,670.6	2,543.7	(126.9)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(358.8)	(136.7)	222.1


Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 593.9 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 179.2 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтэд 1,358.2 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 228.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Гадаад зээлийн үйлчилгээний зардалд 681.0 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний зардалд 148.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1106 төсөл, арга хэмжээний 1,685.1 тэрбум төгрөг батлагдсанаас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1101 төсөл, арга хэмжээний 1,418.9 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 5 төсөл, арга хэмжээний 266.2 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 1101 төсөл, арга хэмжээнээс 458 төсөл, арга хэмжээ шинээр, 643 төсөл, арга хэмжээ нь он дамжин шилжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл 1,311.5 тэрбум төгрөг буюу 92.4 хувийн биелэлттэй байна. Мөн барилга байгууламжийн 787 төсөл, их засварт 169, Тоног төхөөрөмжийн шинэчлэлд 118, Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах 27 төсөл, арга хэмжээ тусгагдан батлагдсан.



Хүснэгт 14. Сүүлийн 5 жилийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	2017	779.3	715.4	91.8
2	2018	766.2	659.2	86.0
3	2019	1,698.1	1,559.9	91.9
4	2020	1,654.3	1,414.88	85.5
5	2021	1,685.18	1,577.81	93.6
Нийт дүн		6,583.08	5,927.19	90.0



Техник, эдийн засгийн үндэслэл: Улсын хэмжээнд хэрэгжих барилга, байгууламжийн төслүүдийн ТЭЗҮ, зураг төслийг мэргэжлийн түвшинд нэгдсэн бодлогоор хангаж, дараа онуудад хэрэгжүүлэх шаардлагатай томоохон

төслүүдийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад 45.4 тэрбум төгрөгийг тусган санхүүжүүлсэн.



COVID-19: Коронавируст халдварт вирусийн тархалттай холбоотойгоор эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэн тэргүүн элжинд санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, эмнэлгүүдэд шаардлагатай хүчилтөрөгчийн гурвалсан системтэй бэсрэг үйлдвэрийг суурилуулах, дижитал рентген суурин болон зөөврийн аппарат, суурин болон зөөврийн эхо аппарат, гемодиализийн аппарат, ангиограф, дурангийн оношилгооны тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай 122.6 тэрбум төгрөгийг шийдвэрлэн санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 15. Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл төсвийн ерөнхийлөн захирагчдаар /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн тоо	Төсөвт өртөг	2021 он төсөв	2021 он гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	1	1,066.6	1,066.6	1,064.5	99.8	2.1
2	Монгол улсын их хурлын дарга	1	3,570.3	3,570.3	3,431.7	96.1	138.6
3	Монгол улсын ерөнхий сайд	35	151,128.8	32,830.4	32,121.0	97.8	709.4
4	Монгол улсын шадар сайд	6	32,646.3	22,015.1	22,011.1	99.9	4.0
5	Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	48	111,547.5	30,963.1	28,663.1	92.5	2,300.0
6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	19	31,998.0	18,045.0	16,814.0	93.1	1,231.0
7	Батлан хамгаалахын сайд	5	13,050.0	6,150.0	6,109.7	99.3	40.3
8	Гадаад харилцааны сайд	2	4,349.4	4,349.4	4,252.6	97.7	96.8
9	Сангийн сайд	9	289,936.5	88,186.3	54,815.3	62.1	33,371.0
10	Хууль зүй, дотоод хэргийн сайд	22	69,098.3	29,157.0	28,854.4	98.9	302.6
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	41	73,109.1	24,635.9	23,576.7	95.7	1,059.2
12	Барилга, хот байгуулалтын сайд	181	425,047.0	193,290.3	182,799.3	94.5	10,491.0
13	Боловсрол, шинжлэх ухааны сайд	354	887,783.2	361,831.5	337,265.0	93.2	24,566.5
14	Соёлын сайд	86	548,984.5	92,839.1	89,725.3	96.6	3,113.8
15	Зам, тээврийн хөгжлийн сайд	108	659,743.3	233,601.4	220,183.8	94.2	13,417.5
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	3,696.9	1,727.1	1,674.8	96.9	52.3

17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	40	50,365.4	21,122.4	20,017.0	94.7	1,105.3
18	Эрчим хүчний сайд	30	153,017.5	38,052.8	36,611.0	96.2	1,441.8
19	Эрүүл мэндийн сайд	96	320,685.5	188,034.7	175,789.5	93.4	12,245.2
20	Авлигатай тэмцэх газрын дарга	2	1,150.0	1,150.0	1,141.1	99.2	8.9
21	Шүүхийн ерөнхий зөвлөл	2	4,000.0	4,000.0	3,694.2	92.3	305.8
22	Улсын ерөнхий прокурор	10	43,517.8	20,312.9	19,951.9	98.2	361.0
23	Монгол улсын ерөнхий аудитор	1	1,497.3	1,497.3	636.2	42.4	861.1
24	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	492.5	492.5	364.1	73.9	128.4
НИЙТ		1101	3,881,481.7	1,418,921.0	1,311,567.4	92.4	107,353.6

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 241 барилга байгууламж ашиглалтад орсон.

- Сургуулийн барилга 22,
- Цэцэрлэг 37,
- Дотуур байр 10,
- Соёлын барилга байгууламж 15,
- Спортын барилга байгууламж 8,
- Эмнэлгийн барилга, өргөтгөл 16,
- Төрийн үйлчилгээний конторын барилга 14,
- Зам тээврийн салбар 44,
- Эрчим хүчний салбар 4
- Барилга хот байгуулалтын салбар 34,
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбар 10,
- Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар 7,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар 5,
- Хууль зүйн салбар 4,
- Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрлэлийн салбар 7,
- Батлан хамгаалах салбар 1,
- Уул уурхайн салбар 1,

Зарцуулагдаагүй үлдэгдэл: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй 107.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийг авч үзвэл 40% нь ажлын гүйцэтгэл ирүүлээгүй, 30% нь газрын асуудал, зураг төсөв, худалдан авах ажиллагааны маргаанаас үүдэн гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээ, 30% батлагдсан төсөвт өртгөөс бага үнийн дүнгээр гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний хэмнэлт.

Концессын эргэн төлөлт: Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийн жагсаалтаар концессын гэрээний дагуу 5 төсөлд 266.3 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс аудитын дүгнэлтэд үндэслэн 266.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, гүйцэтгэл 99.9 хувьтай байна. Концессын гэрээний дагуу 2021 онд “Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт” төсөл болон 300 ортой төрх эмнэлгийн барилгын эргэн төлөлтийг бүрэн төлсөн.

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2021 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.2-т “Засгийн газрын нөөц сан нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2021 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг 100 хувь төсвөөс санхүүжихээр тусгасан. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 16. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/	
Үзүүлэлт	Дүн
2021 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө	100.0
Засгийн газрын тогтоолын нийт дүн	112.8
Үүнээс: 2019-2020 оны тогтоолын дүн	14.0
2021 оны тогтоолын дүн	86.0
Санхүүжүүлсэн нийт дүн	100.0
Санхүүжүүлээгүй дүн	-
Тогтоолын үлдэгдэл	12.8
Санхүүжүүлээгүй хүлээгдэж буй гүйцэтгэл	-

Засгийн газрын нөөц сан нь 2021 онд 100.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 2021 онд Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр Засгийн газрын 34 тогтоол 92.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Засгийн газрын тогтоолуудын дагуу 2021 онд нийт 100.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын нөөц сангаас 2021 онд дэлхий нийтээр тархаад байгаа коронавируст цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд 73.4 тэрбум төгрөг, байгалийн гамшиг, аюултай үзэгдлийн хохирол болон бусад арга хэмжээнд 26.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

3. ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд тус санд 2021 онд 1,062.4 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 967.0 тэрбум төгрөг төвлөрөн 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар тус сангийн хуримтлал 2,565.9 тэрбум төгрөг байна.

4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой баялгийн сан бөгөөд төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

2021 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,456.1 ам. доллар, нүүрсний үнийг 76.3 ам.доллар байхаар тооцож Төсвийн тогтворжуулалтын санд 612.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Дэлхийн зах зээл дээрх зэсийн зах зээлийн үнэ харьцангуй өндөр гарсны улмаас Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс 15.2 тэрбум төгрөгөөр илүү буюу 627.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн тогтворжуулалтын сангаас Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т заасны дагуу 728.8 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлсэн байна.

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2021 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 951.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,002.0 тэрбум төгрөг төвлөрч, 105.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 17. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	951.3	1,002.0	-50.8
Татварын орлого	506.5	476.5	30.0
Нийгмийн даатгалын орлого	951.3	1,002.0	-50.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,074.3	1,200.9	126.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,210.7	1,208.1	-2.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49.9	47.4	-2.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3.7	3.4	-0.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.6	0.6	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.1	0.1	0.0
Хангамж, бараа материалын зардал	0.2	0.2	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1.0	1.0	0.0
Томилолт, зочны зардал	0.1	0.07	0.03
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.0	1.6	0.4
Бараа үйлчилгээний бусад зардал	42.0	40.4	1.6
ТАТААС	61.2	61.2	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	61.2	61.2	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,099.6	1,099.5	-0.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,099.6	1,099.5	-0.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	0.5	0.4	-0.1
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.08	0.08	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.1	0.07	0.03
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.3	0.27	0.03
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-136.4	-7.2	129.2
Эргэж төлөгдөх зээл	-136.4	-7.2	129.2
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-123.0	-198.9	-75.8

АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-123.0	-198.9	-75.8
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-123.0	-198.9	-75.8

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2021 онд 1,200.9 тэрбум төгрөг буюу 111.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сан нь 198.8 тэрбум төгрөгийн алдагдалтай тайлагнагдаж байна.

6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2021 онд 2,398.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс 2,732.0 тэрбум төгрөг төвлөрч, 113.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 2,137.1 тэрбум төгрөг төвлөрч 118.5 хувийн биелэлттэй, улсын төсвөөс олгох татаас 594.9 тэрбум төгрөгт хүрч 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 18. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,398.7	2,732.0	333.3
Татварын орлого	2,398.7	2,732.0	333.3
Нийгмийн даатгалын орлого	2,398.7	2,732.0	333.3
Татварын бус орлого	594.9	594.9	0.0
Тусламжийн орлого	594.9	594.9	0.0
Хандив тусламж /дотоод/	594.9	594.9	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,490.5	2,535.8	45.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,594.3	2,565.6	(28.7)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26.4	25.8	(0.6)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19.1	18.9	(0.2)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.4	2.4	0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1.1	1.1	0
Хангамж, бараа материалын зардал	0.1	0.1	0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.2	0.2	0
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.3	2.1	(0.2)
Бараа үйлчилгээний бусад зардал	0.2	0.1	(0.1)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,567.9	2,539.8	(28.1)
Бусад урсгал шилжүүлэг	2,567.9	2,539.8	(28.1)
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,566.8	2,538.8	(28.0)
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.3	0.3	(0.0)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.8	0.7	(0.1)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	(0.0)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(91.9)	196.2	288.1
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91.9	(196.2)	288.1
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	91.9	(196.2)	288.1

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 онд 2,535.8 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 101.8 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Нийгмийн даатгалын сан нь 2021 онд 196.2 тэрбум төгрөгийн ашигтай тайлагнагдаж байна.

7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 3,692.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 2.5 хувь буюу 88.6 тэрбум төгрөгөөр давж төвлөрсөн байна. Харин нийт зарлага 3,883.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 9.8 хувь буюу 382.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Хүснэгт 19. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,604.1	3,692.7	88.6
Татварын орлого	1,571.5	1,652.6	81.1
Орлогын албан татвар	1,050.5	1,114.5	64.0
Хөрөнгийн албан татвар	183.0	201.1	18.1
Бусад татвар, төлбөр, хураамж	338.0	337.0	-1.0
Бусад нийтлэг төлбөр, хураамж	100.0	108.2	8.2
Газрын төлбөр	166.0	143.9	-22.1
Байгалийн нөөц ашигласны төлбөр	62.8	77.9	15.1
Бусад татвар	9.3	7.0	-2.3
Татварын бус орлого	2,032.5	2,040.1	7.5
Нийтлэг татварын бус орлого	230.5	261.1	30.6
Хөрөнгийн орлого	1.4	2.0	0.6
Тусламжийн орлого	15.7	11.3	-4.4
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,784.9	1,765.6	-19.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,883.5	3,501.4	-382.1
УРСГАЛ ЗАРДАЛ	3,211.8	3,044.9	-166.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,378.0	2,259.5	-118.5
ХҮҮ	6.0	6.0	0.0
ТАТААС	190.1	175.5	-14.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	637.5	603.9	-33.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	634.1	438.5	-195.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	37.6	17.9	-19.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-279.4	191.3	470.7
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	279.4	-191.3	-470.7
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	279.4	-191.6	-470.9
Өмч хувьчлал	59.8	292.1	232.3

Орон нутгийн орлогын 44.8 хувь татварын орлогоос, 55.2 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 69.4 хувь буюу 1,147.3 тэрбум төгрөг

хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 32.8 тэрбум төгрөгийг олгосон байна. Татварын бус орлогын 86.5 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт /1,358.2 тэрбум/, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг /179.2 тэрбум/, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг /228.3 тэрбум/ -ийн орлогууд бүрдүүлж байна.

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 87.0 хувь буюу 3,044.9 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,113.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 438.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 195.6 тэрбум төгрөгөөр бага байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 526.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 62.3 хувьтай тэнцэж байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 26.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 50.7 хувьтай байна.

Хүснэгт 20. Засгийн газрын өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2019.12.31	2020.12.31	2021.12.31
I. Засгийн газрын дотоод өр	1,399.6	1,136.6	657.3
1.1 Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3
II. Засгийн газрын гадаад өр	20,728.1	24,850.7	24,693.3
2.1 Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6
2.2 Зээл	12,800.8	16,496.7	16,517.7
III. Засгийн газрын өрийн баталгаа	1,076.3	1,060.4	876.5
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс	995.7	850.2	673.9
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	24,199.7	27,897.9	26,918.1
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	20,525.6	23,024.3	21,837.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	75.0%	70.0%	70%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	55.1%	62.3%	50.7%
Засгийн газрын өр/ДНБ	64.9%	75.5%	62.6%

Засгийн газрын өрийн багцын 91.7 хувийг Засгийн газрын гадаад үнэт цаас, зээл, 2.4 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас, 3.8 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 2.5 хувийг “барих-шилжүүлэх” төрлийн концесс тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 1,604.0 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 958.1 тэрбум төгрөгийн хүү, шимтгэлийн төлбөр, нийт 2,562.1 тэрбум төгрөгийн төлбөр төлөгдсөн.

Хүснэгт 21. Засгийн газрын 2021 оны өрийн үйлчилгээ/тэрбум төгрөг/

№	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Үндсэн төлбөр	1,386.5	4,251.9
1.1	2021 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндсэн төлбөр	1,386.5	1,226.2
1.1.1	Гадаад зээл	724.2	732.8
1.1.2	Дотоод үнэт цаас	263.0	493.4
1.2	2021 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан арга хэмжээ– Гадаад үнэт цаас	Өрийн зохицуулалт	3,025.7
2	Хүүгийн төлбөр	1,102.5	958.1
2.1	Гадаад зээл	268.5	212.9


2.2	Гадаад үнэт цаас	545.9	597.8
2.3	Дотоод үнэт цаас	288.2	147.4
3	Нийт төлбөр	2,489.0	5,203.0

Үүнээс Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд Засгийн газрын гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилгоор “Сенчири” бондыг арилжаалж, Чингис болон Гэрэгэ бондын зарим хэсэг болох нийт 944.5 сая ам.доллар буюу 2,647.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг хугацаанаас өмнө төлж барагдуулсан. Мөн Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан гадаад, дотоод зээллэгийн төлбөрт 1,226.2 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг төлсөн.

8.1. ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,136.6 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 657.3 тэрбум төгрөг болж, 493.4 тэрбум төгрөгөөр буураад байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл буурсан нь Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зогсоож 2018-2021 онд шинээр арилжаалаагүйтэй холбоотой.

Зураг 6: Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл / тэрбум төгрөг/



Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 511.6 тэрбум төгрөг буюу 77.8 хувийг Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 110.7 тэрбум төгрөг буюу 16.8 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 35.0 тэрбум төгрөг буюу 5.3 хувийг Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна. Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 493.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 147.4 тэрбум төгрөг, нийт 640.8 тэрбум төгрөгийг төлсөн.

8.2. ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 8,354.0 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 8,175.6 тэрбум төгрөг болоод байна.

Хүснэгт 22. Засгийн газрын гадаад үнэт цаасны 2021 оны үлдэгдэл

№	Гадаад үнэт цаас	Гаргасан дүн	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Үлдэгдэл 2021.12.31	
						сая ам.доллар	тэрбум төгрөг
1	Чингис-2022	1000 сая ам.доллар	2012/12/05	5.125%	10 жил	136.8	389.7
2	Хуралдай	600 сая ам.доллар	2017/03/09	8.750%	7 жил	600.0	1,709.3
3	Гэрэгэ	800 сая ам.доллар	2017/10/26	5.625%	5.5 жил	533.1	1,518.6
4	Номад	600 сая ам.доллар	2020/10/07	5.125%	5.5 жил	600.0	1,709.7
5	Сенчири 2027	500 сая ам.доллар	2021/07/07	3.500%	6 жил	500.0	1,424.4
6	Сенчири 2031	500 сая ам.доллар	2021/07/07	4.450%	10 жил	500.0	1,424.4
НИЙТ						2,869.9	8,175.6

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт заасан 1 дүгээр зорилтын хүрээнд Засгийн газар 2021 оны 07 дүгээр сарын 07-ны өдөр 1000.0 сая ам.долларын "Сенчири" бондыг 4.450 болон 3.500 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээлд арилжаалж 2023 оны 4 дүгээр сард төлөгдөх хуваарьтай 300.0 сая ам.долларын Гэрэгэ бонд тодорхой хэсгийг, 2022 оны 12 дугаар сард төлөгдөх хуваарьтай 1.0 тэрбум ам.долларын Чингис бондыг тус тус буцаан худалдан авч өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт нийт 2,647.9 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үүнээс Мазаалай бондын үндсэн төлбөрт 377.8 тэрбум төгрөг, Чингис бондын үндсэн төлбөрт 1,887.4 тэрбум төгрөгийг, Гэрэгэ бондын төлбөрт 760.6 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Засгийн газрын гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 597.8 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөнөөс "Чингис" үнэт цаасны хүүгийн төлбөрт 212.5 тэрбум төгрөг, "Мазаалай" үнэт цаасны хүүгийн төлбөрт 20.5 тэрбум төгрөг, "Хуралдай" үнэт цаасны хүүгийн төлбөрт 149.6 тэрбум төгрөг, "Гэрэгэ" үнэт цаасны хүүгийн төлбөрт 116.9 тэрбум төгрөг, "Номад" бондын хүү шимтгэлийн төлбөрт 87.8 тэрбум төгрөг, Сенчири бондын төлбөр 10.5 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

8.3. ГАДААД ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2021 он хүртэлх хугацаанд нийт 6.7 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласан байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2020 оны эцэст 16,497.4 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 16,517.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 61.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23. Гадаад зээлийн үлдэгдэл /2021 оны жилийн эцсийн гүйцэтгэл тэрбум төгрөгөөр/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хувь
1	Арилжааны зээл	171.0	-	171.0	0.0	0.0	0.0%
2	Төслийн зээл	11,136.5	1,106.4	418.0	450.3	11,374.6	62.3%
3	Хөтөлбөрийн зээл	5,189.9	285.0	143.8	187.0	5,144.1	33.0%
НИЙТ		16,497.4	1,391.4	732.8	637.3	16,497.4	100.0%

Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 96 төсөл, хөтөлбөрийг хүрээнд 2021 онд нийт 1,391.4 тэрбум төгрөгийг авч ашигласнаас төслийн зээлийн ашиглалтад 1,106.4 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээлийн ашиглалтад 285.0 тэрбум төгрөгийг тус тус шинээр ашигласан байна.

Хэрэгжиж буй төслүүдийн томоохон ашиглалтуудаас дурдвал: БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр" төсөлд 86.5 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Эрүүл мэндийн салбарыг чадавхжуулах" төсөлд 285.0 тэрбум төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Цар тахлын үед эрүүл мэндийг салбарыг дэмжих" төслийн хүрээнд 92.6 тэрбум төгрөг, Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Улаанбаатар-Дархан чиглэлийн 2 эгнээ зам барих төслийн хүрээнд 49.4 төгрөгийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж 2020 онд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 945.7 тэрбум төгрөгийг төлсөн. Үүнээс 732.8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрт, 212.9 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн.

8.4. БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ ТӨРЛИЙН КОНЦЕСС

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчилсан бөгөөд хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 850.2 тэрбум төгрөг байсан бол 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 673.9 тэрбум төгрөг байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 10 гэрээний үлдэгдэл 673.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 2 гэрээний үлдэгдэл 0.4 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 24: Барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл, (тэрбум төгрөг)

“Барих-шилжүүлэх” төрлийн Концесс	Төслийн тоо	Гэрээний дүн	Үлдэгдэл
Улсын төсөв	10	1,183.7	673.5
Гүйцэтгэл 100%	9	990.2	565.2
Гүйцэтгэл 50-99%	1	193.5	108.3
Орон нутаг	3	0.64	0.4
Говь-Алтай аймаг	2	0.04	0.04
Ховд аймаг	1	0.60	0.36
НИЙТ	13	1,184.3	673.9

8.5. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,060.4 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 876.5 тэрбум төгрөг болж, 183.9 тэрбум төгрөгөөр буурсан. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банкны баталгааны үлдэгдэл 820.9 тэрбум төгрөг, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн баталгааны үлдэгдэл 29.1 тэрбум төгрөг, Эрдэнэс Монгол ХК-ний баталгааны үлдэгдэл 26.5 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 25. Засгийн газрын өрийн баталгааны 2021 оны үлдэгдэл

#	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	Зээллэг авсан огноо	2021.12.31		
					үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг	Сая USD
1	МИАТ ХК	PEFCO	Ам.доллар	12/24/2013	10.2	29.1	10.2
2	Монгол Улсын Хөгжлийн банк	Japan Investors	Иен	1/6/2014	30,000.0	744.0	261.2
3	Монгол Улсын Хөгжлийн банк	China Dev. bank	Ам.доллар	9/3/2014	27.0	76.9	27.0
4	Эрдэнэс Монгол ХХК	ADB	Ам.доллар	4/1/2016	9.3	26.5	9.3
НИЙТ						876.5	307.7

Тайлант хугацаанд Засгийн газрын баталгаатай 2015 онд гаргасан Худалдаа хөгжлийн банкны 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаас, Засгийн газрын баталгаатай 2013 онд гаргасан "МИАТ" ТӨХК-ны 24.0 сая ам.долларын дэд зээлийн төлбөрүүдийг баталгаа гаргуулагч аж ахуйн нэгжүүд болох Худалдаа хөгжлийн банк, "МИАТ" ТӨХК бүрэн төлж дуусгаснаар Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлээс хасагдсан. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн 78.0 хувийг эзэлж байгаа Монгол улсын хөгжлийн банкны 30.0 тэрбум иений Самурай бондын төлбөр 2023 онд төлөгдөх хуваарьтай бол "МИАТ" ТӨХК-ний зээл 2023 онд, Монгол улсын хөгжлийн банкны Хятадын хөгжлийн банкны зээл 2022 онд, Эрдэнэс Монгол ХК-ийн техник туслалцааны зээл 2031 онд тус тус төлөгдөж дуусах хуваарьтай байна.

8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2021 он хүртэлх хугацаанд нийт 6.8 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласнаас 1.8 тэрбум ам.долларыг дотоодын аж ахуй нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2020 оны эцэст 2,988.7 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 267.6 тэрбум төгрөгийг нэмж олгон, олгосон зээлийн эргэн төлөлтөд нийт 96.7 тэрбум төгрөгийн /үүнээс үндсэн төлбөрт 65.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 30.9 тэрбум төрөг/ орлогыг төсөвт төвлөрүүлж жилийн эцсийн гүйцэтгэлээр үлдэгдэл 3,105.7 тэрбум төгрөг байна. Тайлант хугацааны эцсийн валютын төгрөгтэй харьцах ханш чангарснаас шалтгаалан дамжуулан зээлийн үлдэгдэл 84.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 26. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	1,416.4	73.3	6.8	12.1	1,447.4
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	1,085.8	194.6	45.6	18.1	1,192.9
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	486.5	(0.3)	13.3	0.8	465.3
НИЙТ	2,988.7	267.6	65.7	31.0	3,105.7

Хүснэгт 27. Гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл салбараар

№	Салбар	2017	2018	2019	2020	2021
1	Жижиг дунд үйлдвэрлэл	100	114	140	204	176.6
2	Зам, тээврийн салбар	334	379	466	513	580.1
3	Нийгмийн халамжийн салбар	18	21	26	11	10.8
4	ОСНААҮ-ий салбар	458	521	639	810	843.8
5	Санхүү, эдийн засгийн салбар	142	162	199	201	168.5
6	Хувийн хэвшлийн хуулийн этгээд	215	245	300	328	320.8
7	Уул уурхайн салбар	73	83	102	90	121.0
8	Харилцаа холбооны салбар	53	61	74	59	54.9

9	Хөдөө аж ахуйн салбар	187	212	261	264	310.6
10	Эрчим хүчний салбар	327	372	456	508	518.5
	НИЙТ	1,909	2,170	2,663	2,988	3,105.7

Эргэн төлөлтийн талаар

Дамжуулан зээлийн эргэн төлөлтөд 2021 онд нийт 96.7 тэрбум төгрөгийг /үүнээс үндсэн төлбөрт 65.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 30.9 тэрбум төгрөг/ төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 28. Дамжуулан зээлийн гэрээний дагуу төлбөрөө 2021 онд бүрэн төлж дууссан зээлүүд

Дугаар	Донор	Эцсийн зээлдэгч	Валют	Хүү [%]	Хугацаа [жил]	Гэрээний дүн
OL-43-1	БНСУ	Ди Би Эм Лизинг ХХК	MNT	2.25	4	10,800,000,000.0
OL-MON-P3	Япон	ДЦС-4 ТӨХК	MNT	2.5	25	34,205,366,156.6
OL-3226MOG	ДБ	Төрийн банк	USD	2.0	20	119,015.7
OL-3659MOG	ДБ	Төрийн банк	USD	3	20	335,468.8
OL-3659MOG	ДБ	Төрийн банк	USD	3	20	355,840.9
OL-4088MOG	ДБ	Төрийн банк	USD	2	16	245,244.2
OL-2301MON	АХБ	Төрийн банк	MNT	5	10	1,913,151,528.5
OL-4330MOG	ДБ	Ази капитал корпорэйшн ББСБ	MNT	6.5	2	86,666,668.0
OL-4330MOG	ДБ	Арвижих капитал ББСБ	MNT	6.5	2	32,666,668.0
OL-4330MOG	ДБ	Болор зоос ББСБ	MNT	6.5	2	34,800,000.0
OL-4330MOG	ДБ	Болор зоос ББСБ	MNT	6.5	2	78,600,000.0
OL-4330MOG	ДБ	Гүмүда финанс ББСБ	MNT	6.5	2	12,666,667.0
OL-4330MOG	ДБ	Жи Эс Би Капитал ББСБ	MNT	6.5	2	320,000,000.0
OL-4330MOG	ДБ	Марико ББСБ	MNT	6.5	2	240,000,000.0
OL-4330MOG	ДБ	Чоно финанс ББСБ	MNT	6.5	2	95,000,000.0
OL-4330MOG	ДБ	Энх-үүд инвест ББСБ	MNT	6.5	2	60,000,000.0
OL-4330MOG	ДБ	Эй Ди Юу финанс ББСБ	MNT	6.5	2	250,000,000.0

ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДАЛ

АСУУДАЛ: МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТУХАЙ
ХУРАЛДААН УИХ-ЫН ЧУУЛГАН
ХЭЗЭЭ: 2022 ОНЫ ... ДУГААР САРЫН-НЫ ӨДӨР
ХААНА: ТӨРИЙН ОРДОН

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД

Д/д	Нэр	Албан тушаал	Холбоо барих утас
1	Болдын Жавхлан	Сангийн сайд	99113555
2	Бат-Өлзийн Бат-эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	
3	Батмөнхийн Батцэцэг	Гадаад харилцааны сайд	
4	Хишгээгийн Нямбаатар	Хууль зүй, дотоод хэргийн сайд	
5	Бэгзжавын Мөнхбаатар	Барилга, хот байгуулалтын сайд	
6	Гүрсэдийн Сайханбаяр	Батлан хамгаалахын сайд	
7	Лувсанцэрэнгийн Энх- Амгалан	Боловсрол, шинжлэх ухааны сайд	
8	Лувсангийн Халтар	Зам, тээврийн хөгжлийн сайд	
9	Гэлэнгийн Ёндон	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	
10	Загджавын Мэндсайхан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	
11	Сэрээжавын Энхболд	Эрүүл мэндийн сайд	
12	Нансалын Тавинбэх	Эрчим хүчний сайд	
13	Аюушийн Ариунзаяа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	

14	Чинбатын Номин	Соёлын сайд	
15	Санжаагийн Наранцогт	Эдийн засаг, хөгжлийн дэд сайд	
17	Батцэнгэлийн Болор-Эрдэнэ	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн дарга	
18	Санжаагийн Мөнгөнчимэг	Сангийн дэд сайд	99075752
19	Жигжидийн Ганбат	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99104599
20	Чойжилсүрэнгийн Тавинжил	Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	99118621
21	Мижиддоржийн Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99190219
22	Чойгүнсэнгийн Чимидсүрэн	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга	99117344
23	Батсүхийн Сүх-Очир	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	99011664
24	Бямбарагчаагийн Тэлмүүн	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	99087638
25	Ганболдын Золбоо	Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газар	99196439
26	Нарангийн Мөнхсүх	Сангийн яамны Төрийн сангийн газрын, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс	99093348
27	Байгалмаагийн Одонтуяа	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын, Өрийн удирдлагын хэлтсийн дарга	91918565
28	Солонгын Тулга	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга	98110000
29	Жамъяншаравын Дэлгэржаргал	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	99100568